

ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТ БА ХҮҮХДИЙН ТЭТГЭЛГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS OF DIVORCE AND CHILD BENEFIT



М.Маралмаа

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 521 дүгээр дамжааны дэд түрүүч

Товч утга:Нийгмийн хамгийн анхдагч бөгөөд хамгийн суурь чухал институт бол гэр бүл билээ. Энэ институт задраад аль эсвэл үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байвал улс орны ирээдүйг бүтээх бяцхан иргэдийн эрх, эрүүл аюулгүй орчинд өсөж бойжих хэрэгцээнд асуудал тулгарах юм. Тэгэхээр гэр бүлийг бүтэн байлгахын тулд улс орны хууль тогтоомж тэр дундаа Гэр бүлийн тухай хууль гол үүрэг оролцоотойгоор хэрэгждэг. Хүүхдийг хуулийн журмаар тэжээн тэтгэх үүрэг нь иргэний журмаар болон эрүүгийн журмаар үүсэх тохиолдол байдаг. Эрүүгийн журмаар гэдэг нь гэмт хэргийн улмаас, гэм хор учруулсны үндсэн дээр 18 хүртэлх насны хүүхдийг тэжээн тэтгэх тухай ойлголт байдаг бол иргэний журмаар гэдэг нь гэр бүл цуцалсны үндсэн дээр үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудал байдаг. Үүнээс иргэний журмаар буюу эцэг, эх нь үр хүүхдээ тэжээн тэтгэх асуудлыг энэхүү илтгэлээрээ хөндөж байгаа болно.

Сүүлийн таван жилийн байдлаар шүүхийн болон захиргааны журмаар 20 гаруй мянган гэр бүл салсан байна. Гэр бүл салалттай холбоотойгоор хүүхдийн тэтгэлгийн асуудал бий болдог. Харин манай улсад салсан гэр бүлийн дөнгөж 20 гаруй хувь нь л ухамсраараа буюу шүүхийн шийдвэр гарсны дараа сайн дураараа хүүхдийн тэтгэлгээ төлдөг бол үлдсэн буюу дийлэнх нь байнга албадан төлүүлэхээр буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оролцоотойгоор төлүүлэхэд хүргэдэг байна.

Гэрлэлт цуцлахад хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нэн тэргүүнд тавигдах бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т зааснаар эцэг, эх шүүхийн өмнө хүүхдийн тэтгэмжийн хэмжээг харилцан

тохиролцож болно . Харин гэрлэлтээ цуцлуулагчид хоорондоо тохиролцоонд хүрэхгүй бол шүүхийн журмаар буюу хуульд заасан үндэслэлээр амьжиргааны баталгаажих түвшинтэй уялдуулан хүүхдийн тэтгэлгийг тогтоодог.

Монгол Улсад жилд дунджаар 16000 гаруй гэр бүл шинээр гэр бүлээ батлуулж байхад 3000 орчим гэр бүл гэрлэлтээ цуцлуулж байна. Эдгээр гэр бүлээ цуцлуулж буй 3000 гаруй гэр бүлийн цаана 4000-5000 гаруй хүүхдийн эрх хөндөгдөж байна гэсэн үг юм. Үүнийг Үндэсний статистикийн хорооны тоон судалгаатай харьцуулан үзье.

Үзүүлэлт	2017 онд	2018 онд	2019 онд	2020 онд	2021 онд
Гэрлэлт цуцлуулсан	2791	2945	2736	2726	2823
Эцэг тогтоолгосон	467	392	465	402	331
Нийт	3438	3337	3201	3128	3154

Дээрх хүснэгтээс хэчнээн гэр бүл шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулсан болон гэр бүлээ батлуулаагүй ч хүүхэдтэй байсан хосуудын гэрлэлт цуцлалт буюу хүүхдийн тэтгэмж тогтоолгосон тухай харж болохоор байна.

Тэгэхээр гэр бүлээ цуцлуулж буй хүмүүсийн тоо ихсэх тусам ард нь үлдэж эрх нь зөрчигдөх хүүхдүүдийн тоо ч мөн ихэссээр л байх юм. Гэр бүл гэдэг хэний ч шахалт шаардлага албан дарамтгүйгээр 100% хувь хүмүүсийн өөрсдийнх нь хүсэл зоригийн үндэс дээр бий болдог нандин бөгөөд чухал нийгмийн харилцаа байтал энэ тал дээр хүмүүс ул суурьгүй хэврэг хандаж байгаа нь харамсалтай. Мөн нэгэнт таарч тохирохоо больсон хүмүүс шүүхээр гэр бүлээ цуцлуулаад хэн нэгэн нь хүүхдийн тэтгэмж төлөх үүрэг хүлээхээд сайн дураараа тэр үүргээ биелүүлэхгүй байгаа нь бүр харамсалтай.

Тиймээс энэхүү илтгэлээрээ хүүхдийн тэтгэмжийг төлүүлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ямар ямар бэрхшээл учирч байгаа талаар судалж тэдгээрийг хэрхэн зохицуулж болох талаар гарц гаргалгааг хайхаар зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хүүхдийн тэтгэмж тогтоолгох тухай шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон боловч хариуцагч буюу хүүхдийн эцэг, эх төлбөрөө зохих ёсоор төлөхгүй буюу шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй


байх тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т “Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой, эсхүл төлбөр төлөгчид тодорхой хугацааны туршид давтамжтай төлбөр төлөх болон бусад үүрэг хүлээлгэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацааны туршид албадан гүйцэтгэж болно.”¹ гэж заасны дагуу тухайн төлбөр авагч тал хэдийд ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандах боломжтой байдаг.

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ТОГТООЛГОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Юуны түрүүнд гэр бүл цуцлахад гэрлэлтээ цуцлуулж буй 2 тал хоорондоо харилцан тохиролцож хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тогтоох боломжтой. Харин хоорондоо харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхээс хүүхдийн насны ангилал, тухайн бүс нутгийн хүн амын амьжиргааны доод түвшинг харгалзан үзэж, тэтгэмжийн хэмжээг тогтоодог.

Хүүхдийн тэтгэлгийн хувь, хэмжээ нь 0-11 насны хүүхдэд тухайн бүс нутгийн амьжиргааны түвшний 50% иар, 11-16 болон тухай хүүхэд сурч буй тохиолдолд 18 нас хүртэл нь амьжиргааны түвшний 100% аар тэтгэмжийг олгохоор тогтоодог байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Хүн амын амьжиргааны 2022 оны доод түвшинг тогтоох тухай” А/11 дүгээр тушаалаар амьжиргааны түвшинг баруун бүс, хангайн бүс, төвийн бүс, зүүн бүс, Улаанбаатар гэж бүсчилсэн байдлаар тогтоосон байна².



Мэдээж тэтгэлэг авч буй хүүхдийг гэр бүлээ цуцлуулсан ч бай эцэг, эх нь хоёулаа зэрэг тэжээн тэтгэх үүрэгтэй 0-11 насны хүүхдийн хувьд нэг талаас нь амьжиргааны баталгаажих түвшингийн 50% иар гэдэг боломжийн. Үүн дээр мэдээж хүүхдийг өсгөж буй тал ч гэсэн адил хувиар тэжээн тэтгэх үүрэгтэй. Харин энэхүү хүүхдэд олгож буй тэтгэлгийн хэмжээг бүс нутгийн байрлалаар тогтоох нь тэгш эрхийн зарчимд нийцэхгүй юм болов уу гэж бодож байна. Учир нь хот газар гэлтгүй хөдөө орон нутаг, баруун зүүн бүс гэлтгүй аливаа бараа бүтээгдэхүүний үнэ, хэрэглээний зардал адилхан. Харин

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он

² Үндэсний статистикийн хорооны тоон судалгаа. 2022 /1212.mn/

ч баруун бүсийн аймгуудаар зарим төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ өндөр байх үзэгдэл элбэг.

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛГЭЭ ТӨЛДӨГГҮЙ ЭЦЭГ, ЭХЭД ОНОГДУУЛДАГ ХАРИУЦЛАГА

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйл, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.3, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйл болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгаж өгсөн. Шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх тухай үндсэн зарчмыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байдаг.

1. Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Зөрчлийн тухай хуулийн 6.20-р зүйлийн 6 дахь хэсэгт

“Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр тогтоосон сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна” гэж заасан байдаг. Тэгэхлээр хуульд зааснаар уг мөнгөө төлөөгүй тохиолдолд нэмээд 100 мянган төгрөгөөр торгох юм.¹

Гэтэл энэ хууль бодит амьдралтай хэрхэн нийцэх вэ? олон жил тэтгэлэг төлөөгүй 5,6 сая болчихсон хүн зөрчлийн 100 мянгаа төлөөд л болчих юм шиг хардлага төрж байгаа юм. Өөрөөр хэлбэл торгуулиа төлөөд хүүхдийнхээ мөнгийг төлөхгүй яваад байх бололцоог олгож байгаа юм. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр

¹ Зөрчлийн тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №41.

төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхээр заасан байна. Үүнд нэмэлтээр хэрвээ эрхээ хасуулсан төлбөр төлөгч албан ажлын болон эрүүл мэндийн шалтгаанаар гадаадад зорчих шаардлагатай болсон тохиолдолд эрхийг нь түр сэргээж болно гэж заасан байна.¹

3. Гэр бүлийн тухай хууль

хүүхдийн тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол дараах хариуцлага хүлээхээр заасан.² Үүнд:Тэтгэлэг төлөх тухай талууд гэрээ байгуулсан бөгөөд тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол учирсан хохирлыг гэрээнд заасан журмаар нөхөн төлнө.


- Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлөх ба алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

Улсын хэмжээнд нийт тэтгэлэг авагч хүүхдүүд болон тэтгэлгээ сар бүр тогтмол авдаг болон тэтгэлгээ сар бүр авдаггүй хуримтлал үүсгэсэн хүүхдүүдийн мэдээллийг дараах графикаар харууллаа.




Хүүхдийн тэтгэлгийг албадан гаргуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирсэн, албадлагын арга хэмжээ авагдсан гүйцэтгэх баримт бичгийн тоон үзүүлэлтийг сүүлийн 4 жилийн байдлаар авч үзье.





2022 оны 10 дугаар сарын байдлаар гүйцэтгэвэл зохих 44,619,679.2 төгрөгийн 13220 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 16,417,935.7 төгрөгийн төлбөрийн 1070 гүйцэтгэх баримт бичгийг бүрэн биелүүлэн ажилласан байна.



Дээрх үзүүлэлтээс харахад жил ирэх тусам хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой гүйцэтгэх баримт бичгийн тоон үзүүлэлт ихсэж байгаа төдийгүй тэдгээрийн шийдвэрлэгдэж буй байдлыг мөнгөн дүнгийн болон гүйцэтгэх баримт бичгийн тоон үзүүлэлтээр харьцуулан үзэхэд төдийлөн хангалттай биш байгаа юм. Тэгвэл хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй байгаа шалтгаан нөхцөлийн судалгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас хийсэн судалгаагаар дараах шалгаан нөхцөлтэй гэж дүгнэсэн байна. Үүнд төлбөр төлөгчийн төлбөрийн чадваргүй байдал, оршин суугаа хаяг тодорхойгүй байдал, хорих ял эдэлж буй байдал, эрэн сурвалжлагдаж буй байдал болон

бусад шалтгааны улмаас хүүхдийн тэтгэлэг хуримтлагддаг, хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй байх үндсэн шалтгааныг үүсгэдэг гэж үзсэн байна. Хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй байх шалтгаан, нөхцөлийн судалгааг тоон үзүүлэлтээр харууллаа.

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛГИЙН ТӨЛБӨР БАРАГДАХГҮЙ БАЙГАА ШАЛТГААН¹

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас санаатайгаар зайлсхийсэн, хүүхдийн тэтгэлгээ төлөөгүй төлбөр төлөгчид холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болох ахлах шийдвэр гүйцэтгэгчээс дараах байдлаар зөрчил шалган шийдвэрлэсэн байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны Мэдээлэл, лавлагаа дүн шинжилгээний хэлтсийн 2021, 2022 оны Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн судалгаа. 2021 онд 122 зөрчил шалган шийдвэрлэснээс 80 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 20,0 сая төгрөгийн торгох шийтгэл, 6 зөрчлийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэж 5,0 сая төгрөг, хүүхдийн тэтгэлгийн 3 төлбөр төлөгчид 0,3 сая төгрөг, 30 төлөгчид 7-30 хоногийн баривчлах, албадан сургалтад хамруулах, 2022 оны эхний 8 сарын байдлаар 110 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулснаас 75 зөрчлийг хялбаршуулан шийдвэрлэж 18,2 сая төгрөгийн торгох шийтгэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 1 холбогдогчийг 2,5 сая төгрөгөөр, хүүхдийн тэтгэлгийн 14

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Уб., 2021. ШШГЕГ-ын 2020 оны үйл ажиллагааны тоон мэдээ., Иргэний захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт. Уб., 2022.

төлөгчид 1,4 сая төгрөгийн торгох, 19 тэтгэлэг төлөгчид 7-30 хоног баривчлах болон албадан сургалтад хамруулах шийтгэл ногдуулсан ажилласан байна.¹

Он	2021	2022
Торгох шийтгэл хүлээсэн	3 төлбөр төлөгч 0.3 сая төгрөг	14 төлбөр төлөгч 1.4 сая төгрөг
7-30 хоног баривчлах, албадан сургалтад хамрагдсан	30 төлбөр төлөгч	19 төлбөр төлөгч

ДҮГНЭЛТ

Дээр дурдсан олон хүчин зүйлүүдээс хамаараад хүүхдийн тэтгэлэг бүрэн төлөгдөхгүй байгаа нь өнөөгийн нийгэмд яахын аргагүй тулгамдаж буй асуудал болоод байгааг харуулж байгаа юм. Мэдээж гэр бүл салалт нь эерэг зүйл биш учраас гэрлэлтээ цуцлуулж буй талууд инээгээд салах нь юу л бол тэр ч утгаараа салалтаас үүсэх үр дагавар хор уршиг нь их байгаа юм. Магадгүй гэр бүл салахад дунд нь хүүхэд байхгүй бол төдийлөн тэдгээрийн хооронд үүсэх маргаан бага гарна. Харин хүүхэд байна гэдэг нь энэхүү тэтгэмжийн асуудлаас эхлүүлээд өөр бусад олон асуудлууд гарч ирэх юм.

Гэр бүл болох, эцэг эх болно гэдэг асар их хариуцлага. Мөн гэр бүлээ цуцлуулна гэдэг ч их хариуцлага. Иргэн бүр Монгол Улсын Үндсэн хуулиар² олгогдсон журамт үүрэг гэж бий түүн дотор үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх гэж байгаа. Гэтэл энэ үүргээ биелүүлж чадаагүй, шүүхээр шийдвэрлэгдэн гэрлэлт цуцлагдсан ч үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхгүй байгаа эцэг эхчүүд олширсоор байгаа нь харамсалтай. Төлбөрийн чадваргүйн улмаас буюу хөдөлмөр эрхэлдэггүйн улмаас хүүхдийн тэтгэмжээ өгөхгүй байгаа гэдэг нь эмгэнэл. Шүүхээр хөдөлмөрийн чадамжгүй л гэж тодорхойлоогүй бол эрүүл саруул хүмүүс хөдөлмөр эрхлэхэд болохгүй зүйл байхгүй байх.

Тэгэхээр хүүхдийн тэтгэмжийг бүрэн гүйцэд цаг хугацаанд нь төлүүлэхэд хамгийн нэгдүгээрт иргэн бүр өөрсдөө ухамсартай, хариуцлагатай байх шаардлага юм. Ингэхийн тулд хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа гэдэг шиг хүүхдийг багаас эхлээд гэр бүлийн талаарх ойлголтыг сайтар өгч гэр бүл зохионо гэдэг ямар их чухал болох, гэр бүл зохиосноор ямар ямар үүрэг хариуцлага хүлээдэг болох талаар сайтар ойлгуулах явдал юм. Дараагаар үнэхээр ухамсраараа үүргээ бүрэн биелүүлж чадахгүй байгаа иргэнд хуулиараа хатуу арга хэмжээ авдаг байх. Энэ нь одоогийн хэрэгжиж

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны Мэдээлэл, лавлагаа дүн шинжилгээний хэлтсийн 2021, 2022 оны Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн судалгаа.

² Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл №1.

буй хууль тогтоомжийн хэрэглээ, хүртээмж, хүрээг илүү чангатгах хэрэгтэй гэсэн үг юм.

Мөн гэр бүл зохиохдоо анхнаасаа маш хариуцлагатай байж цаашид учирч болох эрсдэлийг сайтар бодож яарсан алхам хийхгүй байх, мөн хууль эрх зүйн талаар тодорхой мэдээлэлтэй байх хэрэгтэй шүү гэж үеийнхээ охид залууст уриалж байна.

САНАЛ

Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад гэр бүлийн тухай хууль болон гэр бүл төлөвлөлт, түүнтэй холбогдох эрх үүрэг хариуцлагын талаарх агуулгыг багтаасан хичээлийг тухайн хүүхдийн нас бие сэтгэл зүйн онцлогт нь тааруулан боловсруулж хичээлийн хуваарьт нь оруулах;

Үндэсний статистикийн хорооны тушаалаар гаргадаг амьжиргааны баталгаажих түвшинг баруун бүс, хангайн бүс, төвийн бүс, зүүн бүс, Улаанбаатар гэж ангилалгүй бүх нийтэд нь эрх тэгш нэгдсэн нэг байдлаар тогтоох;

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр тогтоосон сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна” гэж заасан байдгийн АЛБАДАН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ гэсэн заалтыг илүү тодорхой буюу оновчтой болгох. Жишээ нь хүүхдийн тэтгэлэг төлөөгүй шалтгаанаар баривчлах шийтгэл болон албадан сургалтад харагдах шийтгэл авсан этгээдэд гаргасан зөрчлийн агуулгат нь тохирох сургалтыг хүүхэд хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулдаг болох.

Хүүхдийн тэтгэлэг хугацаандаа төлөгддөггүй шалтгаануудаас хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь төлбөрийн чадваргүй гэсэн шалтгаан байна. Хөдөлмөр эрхлэх чадвартай ч ажил хийдэггүй, цалин орлоггүйгээс болж хүүхдийн тэтгэлэгээ төлж чаддаггүй эцэг эхчүүдийг ажлын байраар хангаж цалингаас нь төлөх ёстой хүүхдийн тэтгэлэгийг гаргуулах зохицуулалтыг зөрчлийн тухай хуульд тусгах.

---o0o---